



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 135

Номгон

**Газрын харилцааны талаар авах  
арга хэмжээний тухай**

Улсын Газрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамж хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий газрын зарим газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газарт зөрүү гарч эзэмшлийн газраас илүү, дутуу гарсан зэрэг зөрчлүүдийг арилгаж бүртгэлжүүлэх шаардлагатай байна. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

1.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрөгдсөн талбайнаас илүү эзэмшиж байгаа болон зөрчилтэй байгаа 200 м<sup>2</sup>-аас бага ашиггүй талбайтай газарт дуудлага худалдааны анхны үнэ дээр дуудах нэг удаагийн интервалыг 2 дахин өсгөн нөхөн төлбөр төлүүлж, газрыг нэмж эзэмшүүлсүгэй.


1.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрөгдсөн талбайнаас илүү эзэмшиж байгаа газар нь 200 м<sup>2</sup>-аас дээш ашигтай талбайтай газруудыг дуудлага худалдаанд оруулан эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлүүлсүгэй.

2. Цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байх талаар анхаарч ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /А.Цэцэнбилэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



1190246